

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн
дэд даргын 2021 оны 23 дугаар тушаалын
22-дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

УХА0064

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

Албан тушаалын нэр:

Төрийн ёслол, бэлэг дурсгалын фонд хариуцсан шинжээч

Ажлын цаг

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Төрийн ёслолын газар

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Ахлах түшмэл, АА-7

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, 14201, Төрийн ордон

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нарын төрийн арга хэмжээний ёслолын үйл ажиллагаанд шаардагдах бэлэг дурсгалын зүйлийг батлагдсан төсвийн дагуу бэлтгэж гардуулах, зарцуулах, тайлагнах үйл ажиллагааг холбогдох журмын дагуу эрхлэн явуулж, гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын үйл ажиллагааны ёслолын арга хэмжээний бэлэг дурсгалын зүйлсийг холбогдох журмын дагуу бэлдэх;
2. Нийтээр тэмдэглэх баярын өдрүүдийн төрийн ёслолын ажиллагаанд шаардлагатай бэлэг дурсгалын зүйлсийг бэлдэх;
3. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нар аймаг орон нутагт ажиллахад ёслолын ажиллагаанд шаардлагатай бэлэг дурсгалын зүйлсийг бэлдэх;

4.Бэлэг дурсгалын зүйлийг бэлдэх, гардуулах, зарцуулах, тайлагнах үйл ажиллагааг холбогдох журмын дагуу эрхлэн явуулах, гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн зарим ажлуудыг хариуцан хийх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нарын гадаад улсад айлчлахад дагалдан явж, ёслол хүндэтгэлийн асуудлыг хариуцаж, агуулга, үзэмж сайтай бэлэг дурсгалын зүйлсийг бэлтгэх;	Дипломат ёслолын хэм хэмжээнд нийцсэн байх	Г
	2.Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдын урилгаар ирэх гадаадын зочин төлөөлөгчдийн айлчлалын бэлтгэл ажлыг хангах, хэрэгжүүлэх, судалгаа хийж агуулга, үзэмж сайтай бэлэг дурсгалын зүйлийг бэлтгэх;		Г
	3.Ерөнхийлөгчийн Тамгын газар, ЗГХЭГ-ын удирдлагуудын гадаад, дотоод айлчлалтай холбоотой бэлэг дурсгалын зүйлсийг бэлтгэх;		Г
	4.Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нарын ивээл дор зохиогдох арга хэмжээнд шаардлагатай бэлэг дурсгалын зүйлийг бэлтгэх.	Үндэсний ёс заншил, уламжлал, ёслолын нийтлэг хэм хэмжээнд нийцсэн байх	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нар хөдөө орон нутагт ажиллахад дагалдан явж, ёслол хүндэтгэлийн асуудлыг хариуцаж, агуулга, үзэмж сайтай бэлэг дурсгалын зүйлсийг бэлтгэх;		Г
	2.Төрийн тахилгат уулын тэнгэрийг тахиx бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулахад оролцох.		Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд, Шадар сайд нарын нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрүүдээр зохиогдох төрийн ёслолын арга хэмжээнд зориулсан бэлгийг бэлтгэх;	Уламжлал, заншил, агуулгад нийцсэн чанартай бэлгийг төсөвт багтаан бэлтгэх	Г, Х
	2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нар тэмдэглэлт ой, байгууллагын үйл ажиллагаатай танилцахад шаардлагатай бэлэг дурсгалын зүйлийг бэлтгэх;	Үндэсний ёс заншил, уламжлал, ёслолын нийтлэг хэм хэмжээнд нийцсэн байх	
	3.Төр, засгийн тэргүүн, ЗГ-ын гишүүдийн төрсөн өдрөөр өгөх бэлэг дурсгалын зүйлсийг бэлтгэх.		



4 дүгээр зорилтын хүрээнд	1.Бэлэг дурсгалын сангийн нөөц бүрдүүлэлтийг улирал тутамд холбогдох газруудаар зардлыг батлуулан хийж байх;		Г, Х
	2.Тайлан тооцоог цаг хугацаанд нь журам зааврын дагуу хийх, баримт бичгийг албажуулан бэлтгэх.	Журамд нийцсэн байх	Г
III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	- санхүү, банк, даатгал /0412/; - менежмент ба удирдахуй /0413/.		
Мэргэшил	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх.		
Туршлага	Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулж харьцуулалт хийх, нэгтгэж дүгнэх; - судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх; - судалгааны дүн, мэдээлэлд тулгуурлан бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж, боловсруулах; - шийдвэрийн шууд ба шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарыг зөвлөх; - бусад.	
	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчлэх; - хуульд нийцсэн, оновчтой шийдвэр гаргах; - асуудлыг хууль журам, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - аливаа асуудлыг шийдвэрлэхдээ хамт олны саналыг харгалзан үздэг байх; - бусад.	
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бусдыг дэмжих, хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - ёс зүйн хэм хэмжээг сахиж, шударга, зарчимч, тууштай байх; - хамт олонч сэтгэлгээтэй, зэрэг уур амьсгалыг дэмждэг байх; - ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг үлгэрлэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - багийн дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - бусад.	
	Бусад	- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, технологийг ашиглах чадвартай байх; - багаар ажиллах, багийн амжилтыг дэмжиж бусдад таниулах; - хувийн ёс зүй, харилцааны соёлтой байх; - жөндөрийн эрх тэгш байдлыг хангах;	



		- төрийн нууцтай танилцах эрх олгохтой холбоотойгоор аюулгүй байдлын шалгалт явуулахыг бичгээр зөвшөөрч, эрх бүхий байгууллагын аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж, тэнцсэн байх; - кирил болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх.
--	--	---

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

-Төрийн ёслолын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

1.Төрийн захиргааны төв байгууллага, Төрийн бусад байгууллага.

2.Төрийн бус байгууллага, Хувийн хэвшлийн байгууллага.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

Байгууллагын нэр:

ДЭД ДАРГА

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

..... У.БЯМБАСҮРЭН

Шийдвэрийн огноо: 2021.09.14

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Дугаар: 217

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Шийдвэрийн огноо:

Тэргүүн дэд даргын 2021 оны ... дүгээр сарын-ны өдрийн тушаал

Дугаар:

(тамга/тэмдэг)

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА

Б.ГАНБАТ

2021 оны ... дүгээр сарын ... -ны өдөр

